

“БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК” ХХК

**Санхүүгийн тайлан болон
Хараат бус аудиторын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31

АГУУЛГА**ХУУДАС**

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН 1

ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН 2

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН 3

МОНГОН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН 4

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД 5

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ 14

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

КОМПАНИЙН НЭР	Бичил Эй Би Эс плас тусгай зориулалтын компани		
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗЭВЛӨЛ	Дарга	Н.Гантулга	
	Хараат бус гишүүн	Ц.Аэбаяр	
	Хараат бус гишүүн	Б.Баасандорж	
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гүйцэтгэх удирдлага томилоогүй		
АЛБАН ХАЯГ	“Бичил Эй Би Эс плас ТЗК” ХХК Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо, 7 дугаар хороолол, Ногоон нуур гудамж, 101 дүгээр барилга, 705 тоот		
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР	9011849203		
РЕГИСТРИЙН ДУГААР	6999131		
ҮЙЛ АЖИЛЛАГАА	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах		
АУДИТОР	Ниямазон Аудит ХХК Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, Чоймболын гудамж, Нийслэлийн үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны байр, 406 тоот		

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороотой,
Ногоон нур, 101 барилга, 705 тоот
Утас: 99119632

2024.04.25 № 25/10
Танай _____ -ны № _____

Удирдлагын мэдэгдэл

“Бичил Эй Би Эс плас ТЗК” ХХК-ийн удирдлага нь санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, Компанийн 2023 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу зохистой толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн зохих зарчмуудыг сонгож, тууштай мөрдеж, үндэслэл бүхий үнэлгээ, тооцоолол хэрэглэсэн;
- Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн;
- Санхүүгийн тайланг үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлийн гэсэн тосооллийг баримтлан бэлтгэсэн.

“Бичил Эй Би Эс плас ТЗК” ХХК-ийн удирдлага нь 2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал, энэ өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг мэдэгдэж байна.

Хүндэтгэсэн,
төлөөлөн удирдах
зөвлөлийн дарга



Н.ГАНТУЛГА



NIYAMAZON AUDIT LLC

#406, Building of Trade Union Federation,
Choimbul street, Chingeltei district,
Ulaanbaatar 15172, Mongolia
Tel: (976) 70145908, 91005906
E-mail: audit@nmz.mn

2024.04.25 № А/24-67

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “Бичил Эй Би Эс плас ТЗК” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусвар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланда аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх “Бичил Эй Би Эс плас ТЗК” ХХК-ийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусвар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу үнэн, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол Улсын Аудитын тухай хуулийн шаардлагын дагуу компаниас хараат бус байж бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайланда хүлээх удирдлагын үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу залилан болон алдаанаас үлмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэхэд шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Санхүүгийн тайлан гаргахдаа удирдлага нь компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх ба нэлөөлөх асуудлыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан болон алдааны үлмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланда үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нэлөөлөх магадлалтай бол материаллагт тооцно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандаж, мэргэжлийн итгэл үнэмшил бүхий үнэлэлтийг хийдэг. Бид мөн:

- Залилан болон алдааны үлмаас үүсч болох санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, тохиорох аудитын горимыг боловсруулж, дүгнэлтийн үндэслэл болохуйц нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зерчих зэрэгтэй холбоотой үүсдэг тул алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.

- Компанийн дотоод хяналтын үр нэлэөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Компанийн үйл ажиллагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлесен цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд мөн багтдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг талуудын хооронд байгуулсан аудитын ажлын гэрээт захидалд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



З.Цээнээ
Захирал
Ниямазон аудит ХХК

Улаанбаатар хот, Монгол Улс
2024 оны 4 дүгээр сарын 25

	Тодруулга	2022 мян.төг	2023 мян.төг
ХӨРӨНГӨ			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3	1,000.0	585,127.2
Дансны авлага	4	-	18,996,447.1
Бусад авлага	5	-	1,855,462.5
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		-	722.4
НИЙТ ХӨРӨНГӨ		1,000.0	21,437,759.2
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Татварын өглөг	6	-	208,939.5
Хүүний өглөг	7	-	40,548.0
Урт хугацаат зээл	8	-	20,000,000.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР		-	20,249,487.5
ЭЗДИЙН ӨМЧ			
Энгийн хувьцаа	12	1,000.0	1,000.0
Хууримтлагдсан ашиг		-	1,187,271.7
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		1,000.0	1,188,271.7
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		1,000.0	21,437,759.2

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛГОСОН
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	Тодруулга	2022 мян.төг	2023 мян.төг
Борлуулалтын орлого	9	-	3,539,859.0
Борлуулалтын өртөг		-	-
Нийт ашиг		-	3,539,859.0
Бусад орлого			
Ерөнхий ба удирдлагын зардал	10	-	325,051.8
Санхүүгийн зардал	11	-	1,895,616.4
Татварын төлөхийн өмнөх ашиг		-	1,319,190.8
Орлогын татварын зардал		-	131,919.1
Цэвэр ашиг (алдагдал)		-	1,187,271.7

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛГОСОН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Энгийн хувьцаа мян.төг	Хуриатлагдсан ашиг мян.төг	Нийт эзний өмч мян.төг
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг	-	1,187,271.7	1,187,271.7
Өмчид гарсан өөрчлөлт	1,000.0	-	1,000.0
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000.0	1,187,271.7	1,188,271.7

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

	2022 мян.төг	2023 мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Бусад мөнгөн орлогс	-	4,897.8
Ажиллагчдад төлсөн	-	1,416.0
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	40.0
Ашиглалтын зардалд төлсөн	-	1,775,537.1
Хүүний төлбөрт төлсөн	-	2,723.0
Татварын байгууллагад төлсөн	-	47,890.0
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	(1,832,503.9)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	22,474,454.1
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	20,057,823.0
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	2,416,631.1
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	584,127.2
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	1,000.0	1,000.0
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	1,000.0	585,127.2

Санхүүгийн тайлангийн тодруулгүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

1. Компанийн талаар мэдээлэл

"Бичил Эй Би Эс плас ТЗК" ХХК нь (цаашид ТЗК гэх) Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 118 дугаар тогтоолоор **хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх** тусгай зөвшөөрөл авч тусгай зориулалтын компани болжээ.

ТЗК-ийн нийтэд санал болгон гаргах 24 сарын хугацаатай, жилийн 18.5 хувийн хүүтэй, нэг бур нь 100.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 200.0 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг СЗХ-ны 2023 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 181 дүгээр тогтоолоор бүртгэсэн байна.

Тус компанийн гаргасан үнэт цаасны танилцуулгын товч мэдээлэл:

Оролцогч байгууллагууд

- | | |
|-------------------------------|--|
| ▪ Үнэт цаас гаргагч: | "Бичил Эй Би Эс плас ТЗК" ХХК |
| ▪ Аххны үүрэг гүйцэтгүүлэгч: | "Бичил глобус финанс ББСБ" ХХК |
| ▪ Андеррайтер | "Өлзий энд Ко капитал УЦК" ХХК |
| ▪ Зээлийн шинжилгээ гаргагч: | "Онч аудит" ХХК |
| ▪ Хуулийн зөвлөх: | "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН |
| ▪ Хөрөнгө итгэмжлэн удирдагч: | "Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК |

Үнэт цаасны мэдээлэл

▪ Үнэт цаасны төрөл	Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
▪ Нэрлэсэн үнэ /төгрөгөөр/	100,000
▪ Тоо ширхэг	200,000
▪ Жилийн хүү	18.5 хувь
▪ Хугацаа	24 сар
▪ Нийт хэмжээ	20,000.0 сая төгрөг
▪ Хүү төлөлт	Улирал тутам
▪ Үндсэн төлбөр талалт	12 дахь сард 50 хувь, хугацааны эцэст 50 хувь
▪ Үнэт цаасны хүүд ногдох татвар	Орлогод ногдох дүнгээс 5.0 хувь
▪ Зээлийн багц	24,237.1 сая төгрөг
▪ Зээлийн тоо	1,468
▪ Зээлийн чанар	100 хувь хэвийн

2. Няглан бodoх бүртгэлийн үндсэн бодлогууд

Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Компанийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу түүхэн өртгөөр бүртгэх тогтсон зарчмыг баримтлан бэлтгэгдсэн ба энэ зарчим нь бодит үнэ цэнээрх тодорхой санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнэ болон бодит үнэ цэнийн үнэлгээн дээр үндэслэн санхүүгийн анхлан хүлээн зөвшөөрөх өөрчлөлтийг тусгасан. Компани өөрийн санхүүгийн байдлын тайланг хөрвөх чадварын дарааллаар толилуулдаг. Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд хэрэглэсэн няглан бodoх бүртгэлийн хураангуйлсан үндсэн бодлогуудыг дор толилуулав. Өөрөөр заагаагүй санхүүгийн тайлагналын хугацааны туршид эдгээр бодлогыг тогтмол баримталдаг.

Няглан бodoх бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, таамаглалууд

Компанийн санхүүгийн тайланг бэлтгэхийн тулд удирдлага нь санхүүгийн тайландаа орлого ба зардал, хөрөнгө ба өр төлбөр, болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, холбогдох тодруулгуудыг бэлтгэхэд шаардлагатай үнэлэмж, таамаглал тооцооллуудыг хийдэг. Няглан бodoх бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг зөвхөн нөлөөлж байгаа тайлант үед эсхүл ирээдүйн болон одоогийн тайлант үеүдэд нөлөөлөх бол ирээдүйн болон одоогийн тайлант үеүдэд тус тус тусгадаг.

Тайлангийн мөнгөн тэмдэгт

Эдгээр санхүүгийн тайлангуудыг барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг эдийн засгийн анхдагч орчны мөнгөн тэмдэгт буюу үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлсэн.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь дуусвар хугацаа нь худалдан авч эзэмшснээс хойш 3 сар болон түүнээс богино хугацаагаар тодорхойлогдсон бөгөөд бодит үнэ цэнэ өөрчлөгдхөхөд өчүүхэн тэдийг эрсдлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, компанийн удирдлага богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшиж буй бэлэн мөнгө болон банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ.

Бараа материал

Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлдог ба бараа материалыг анх олж эзэмшсэн өртгөөр нь бүртгэлд тусгана. Байнгын системээр бараа материалын бүртгэлийг хөтөлж буй үед тайлант үеийн эцэс бүр бараа материалын бүртгэлээр тодорхойлсон дүн нь биет тооллогын дүнгээс зөрүүтэй байвал бараа материалын дүнд залруулах бичилт хийдэг. Хэрэв бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ нь анх олж эзэмшсэн өртгөөс бага тохиолдолд бараа материалын үнэ цэнийн бууралтын гарз үүсэх бөгөөд уг гарзыг тухайн тайлант хугацаанд үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Цэвэр боломжит үнэ цэнэ гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад бараа материалыг худалдан борлуулахаар тооцоолж буй үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүн юм.

Урьдчилгаа төлбөр

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь хараахан гараагүй төлбөр эсвэл хүлээн аваагүй бараа материалын төлбөрөөс бүрдэнэ. Урьдчилгаа төлбөрийг анх өртгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд эсвэл хугацаа дусах үед ашиг, алдагдал руу болон бараа материалыг хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгөнд ангилдаг.

Урьдчилгаа төлбөртэй холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагадаа бол урьдчилгаа төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайландаа эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд эргэлтийн бус хөрөнгөөр ангилна.

Тайлант жилийн эцэст компани урьдчилгаа төлбөрийн дансны үнэд хяналт тавьж, үнэ цэнийн бууралт гарсан эсэхийг тодорхойлдог.

Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрүүдийг компани тухайн хэрэглүүртэй холбоотой гэрээт тал болох үед нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх бодит үнэ цэнээр нь бүртгэх ба үүнд гэрээт харилцагчдаас үссэн дансны авлагыг СТОУС 9-ийн дагуу анх бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр/ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслээс бусад/-ийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг анх бүртгэлд тусгахдаа санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дээр нэмж эсвэл өр төлбөрийн бодит үнэ цэнээс хасаж бүртгэнэ.

Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг тухайн жилийн ашиг, алдагдлаар бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгө

Ердийн журмаар худалдах, худалдан авах санхүүгийн хөрөнгийг бодит гүйлгээ гарсан өдрөөр нягтлан бодох бүртгэлд тусгах эсвэл бүртгэлээс хасдаг.

Ердийн журмаар худалдах, худалдан авах гэдэг нь тогтоосон хугацааны дотор эсвэл тухайн зах зээл дээр тогтсон дүрэм журмаар хөрөнгийг шилжүүлэх нехцэлеөр санхүүгийн хөрөнгийг худалдах, худалдан авахыг хэлнэ.

Санхүүгийн хөрөнгийг ангиллаас нь хамааран анх бүртгэсний дараа хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Дараах нехцелүүдийг хангасан өрийн хэрэгслүүд нь дараа үеүдэд хорогдуулсан өртгөөр хэмжигдэнэ.

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой бизнесийн загвараар эзэмшдэг болон

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцөлөөр тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэгслийг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжинэ./БДОБҮЦ/

- Мөнгөн урсгалыг цуглувулахын тулд эсвэл арилжаалах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилго бүхий бизнесийн загвараар эзэмшдэг болон
- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцөлаар тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх

Бусад бүх санхүүгийн хөрөнгийг дараа үед ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнэ /АЛБҮЦ/-ээр хэмжинэ.

Хорогдуулсан өртөг болон үр ашигт хүүгийн арга

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өрийн хорогдуулсан өртгийг тооцоолон хүүгийн орлогыг урт хугацааны туршид хуваарилах арга юм.

Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгөөс бусад /анхлан хүлээн зөвшөөрөхдөө үнэ цэнэ нь буурсан хөрөнгө/ санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр /үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан/-ийг санхүүгийн өрийн гэрээний хугацааны эцэс гэхэд анх бүртгэсэн цэвэр дансны үнэтэй тэнцүү байхаар үнэ цэнийн бууралтын нөөцийг хасахын өмнөх төлбөрийг өрийн хугацаа эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хуваарилахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

Санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн дунгээс үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж анхны дүн ба дуусвар болох үеийн дунгийн хооронд үүссэн аливаа зөрүүг үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон хорогдуулгыг нэмж аливаа алдагдлын нөөцийг тохируулсан дунгээр тодорхойлогдоно.

Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь аливаа алдагдлын нөөцөөр тохируулаагүй дүн байна.

Хүүгийн орлогыг анх үр ашигт хүүгийн түвшин ашиглан хорогдуулсан өртгөөр болон БДОБҮЦ-ээр хэмжигдэх бүх өрийн хэрэгслийдийн хувьд бүртгэдэг. Зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хүүгийн орлогыг тухайн санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэд үр ашигт хүүгийн түвшинг ашиглах замаар тооцоолно.

Дараа тайлант үед зээлийн үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хувьд тухайн хөрөнгийн хорогдуулсан өртөгт үр ашигт хүүгийн түвшин ашиглах замаар тодорхойлно. Санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл дараа тайлант үед сайжирч санхүүгийн хөрөнгө нь зээлийн үнэ цэнийн бууралтгүй болсон ч гэсэн тооцооллыг нийт сууриар буцаахгүй.

Хүүгийн орлогыг тайлант үеийн ашиг, алдагдлаар тайлагнадаг ба санхүүгийн орлого хэсэгт ангилаа.

Компани нь зөвхөн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусвар болсон эсвэл санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх ба хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг бусдад шилжүүлсэн үед санхүүгийн хөрөнгийг данснаас хасна. Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийг данснаас хасахдаа тухайн хөрөнгийн дансны үнэ ба хүлээн авсан дүн болон авлагын нийлбэрийн зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөр ба өмч

Гэрээний зохицуулалтын агуулга болон санхүүгийн өр төлбөр болон өмчийн хэрэгслийн тодорхойлолтын дагуу өр болон өмчийн хэрэгслийг санхүүгийн өр төлбөр эсвэл өмч гэж ангилдаг.

Өмчийн хэрэгсэл

Компанийн бүх хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгээс хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэдэг. Группээс гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дунгээр хэмжиж бүртгэдэг.

Энгийн хувьцаа

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын аливаа нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

Хувьцаат капиталыг буцаан худалдан авах /халаасны хувьцаа/

Хувьцаат капиталыг буцаан худалдан авсан үед аливаа татаврын нөлөөллийн дараах худалдан авахтай холбоотой гарсан шууд зардлыг багтаасан дүнгээр эздийн өмчийн бүртгэл гэж бүртгэдэг.

Буцаан худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж нэрлэх бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланд халаасны хувьцаа гэж тайлагнадаг.

Хувьцаат хувьцааг дахин борлуулсан эсвэл дахин эргэлтэнд гаргасан үед хүлээн авсан дүнг өмчийн өсөлтөөр бүртгэдэг бөгөөд тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан өсөлт, бууралтыг нэмж төлөгдсөн капитал гэж толилуулдаг.

Хуриимтлагдсан ашиг

Хуриимтлагдсан ашиг нь компанийн өмчийн эздэд ногдох ашгаас зарлсан ногдол ашгийг хассан дүн болно. Стандартад шилжилтийн шаардлагын дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөс үссэн нөлөөллийг хуриимтлагдсан ашигт бүртгэдэг.

Эздийн оруулсан хөрөнгө оруулалт

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс өмнө болон бусад мөнгөн бус хөрөнгөөр сайн дурын үндсэн дээр оруулсан хөрөнгө оруулалт нь тухайн хөрөнгийн бодит үнэ цэнээр эздийн өмчид шууд бүртгэгддэг.

Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц

Хөрвүүлэлтийн нөөц нь гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайлангийн хөрвүүлэлтээс үссэн гадаад валютын ханшийн зөрүү болон компанийн гадаадын охин компанийд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтыг хэйджинг хийсэн өр төлбөрийн хөрвүүлэлтээс үссэн гадаад валютын хашийн зөрүүнээс бүрдэнэ.

Санхүүгийн өр төлбөр

Бүх санхүүгийн өр төлбөрийг анх бүртгэсний дараа үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Компанийн санхүүгийн өр төлбөр нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хэрэгслүүдээс бүрддэг.

Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцож холбогдох хугацааны туршид хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр /үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан/-ийг санхүүгийн өр төлбөрийн хугацааны туршид эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хорогдуулахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

Санхүүгийн өр төлбөрийг данснаас хасах

Компани нь санхүүгийн өр төлбөрийг гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд данснаас хасна. Данснаас хасаж буй санхүүгийн өр төлбөрийнг дансны үнэ ба төлсөн дүн болон өглөгийн нийлбэрийн зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Орлого хүлээн зөвшөөрөлт

Бараа борлуулсны орлого, хөрөнгөө бусдад ашиглуулсны болон үйлчилгээ үзүүлсний орлогыг хүлээн авсан Эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр нь хэмжих ба гарсан аливаа худалдаа, үйлчилгээний буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралт зэргийг хассан цэвэр дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.

Үйлчилгээ үзүүлсний орлого

Үйлчилгээний орлогод гэрээгээр гүйцэтгэсэн үйлчилгээний орлого хамаарна. Эдгээр орлогууд нь үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд орлогоор хүлээн зөвшөөрөгднө.

Үйлчилгээнээс орох орлогыг тухайн ажил гүйлгээний тайлагналын өдрөөрх гүйцэтгэлийн үйл явцтай нь үялдуулан ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үйлчилгээний гүйцэтгэлийн үйл явцыг гүйцэтгэсэн ажилд хийсэн судалгаанд үндэслэн үнэлдэг.

Бараа борлуулалтын орлого

Компани барааны өмчлөлтэй холбогдон үүсэх мэдэгдэхүйц эрсдэл эсвэл өгөөжийг худалдан авагч талд шилжүүлсэн, борлуулсан барааныхаа өмчлөлд холбогдох аливаа удирдлагын болон хяналтын үүргийг өөртөө хадгалаагүй, орлогын дунг найдвартай хэмжих боломжтой, тухайн ажил гүйлгээний эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлалтай богоод тухайн ажил гүйлгээстэй уялдаж гарсан ба цаашид гарах зардлыг найдвартай хэмжин тодорхойлж болохоор байгаа үед орлогыг хүлээн зөвшөөрдөг.

Гадаад валютын ажил гүйлгээ

Компанийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн тайлагналын валютаас бусад валютыг (гадаад валют) ажил гүйлгээ гарсан өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэсэн.

Төгрөгөөс бусад мөнгөн тэмдэгт нь гадаад валют гэж тооцогдог ба гадаад валютаар хийгдсэн гүйлгээнүүдийг тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар төгрөг рүү хөрвүүлдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө, хөрөнгө болон өр төлбөрүүдийн гүйлгээ хийгдсэн өдрөөс хойших ханшийн өөрчлөлтөөс үүсэн гарах өөрчлөлтийг гарсан цаг хугацаанд нь ашиг алдагдлаар бүртгэнэ.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус эүйлсийн хөрөнгө ба өр төлбөрийг тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар хөрвүүлдэг. Ханшийн зөрүүнээс үүссэн зөрүүг орлогын дэлгэрэнгүй тайланда тусган эздийн өмчийн хэсэгт хуримтуулан бүртгэнэ.

Зардал хүлээн зөвшөөрөлт

Зардлыг орлогын дэлгэрэнгүй тайланда зардлын чиг үүргийн аргыг ашиглан тайлагнадаг. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт борлуулсан барааны бүтээгдэхүүнтэй шууд холбоотой зардлууд багтдаг. Компанийн үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын, борлуулалт ба маркетингийн болон бусад бизнесийн үйл ажиллагааны зардлууд ордог.

Санхүүгийн зардал

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрдэх ба ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөн бүртгэлд тусгагддаг. Шалгуурт нийцсэн хөрөнгийн олж бэлтгэх, барьж байгуулах ба үйлдвэрлэхэд шууд холбоотой хүүгийн зардлыг тэдгээр хөрөнгийн өртөгт оруулж бүртгэдэг. Шалгуурт нийцсэн хөрөнгө гэдэг нь түүнийг зориулалтаар нь ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход их хэмжээний хугацаа зарцуулдаг хөрөнгийг хэлэх ба уг хөрөнгийг ашиглах ба борлуулахад бэлэн болгох хүртэлх хугацаанд хүүгийн зардлыг хөрөнгийн өртөгт оруулдаг.

Зориулалт нь тодорхой зээлийг холбогдох хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж эхлэх хүртэл эсвэл борлуулахад бэлэн болсон нь тодорхой болсон үед зээлийг ерөнхий зээлийн капиталжуулалтын түвшинг тооцох зорилгоор зээлийн ерөнхий санд байлгадаг. Тодорхой зээлийг түр хугацаагаар хөрөнгө оруулалт хийх зорилгоор олж авсан хөрөнгө оруулалтын орлого нь шаардлага хангасан хөрөнгөнд зарцуулагдах хүртэл хүлээгдэж байна. Зээлийн хүүгийн зардлаас хасаж хөрөнгийн зориулалт нь тодорхой зээлээрх түр хөрөнгө оруулалтаас олсон хөрөнгө оруулалтын орлогын зарцуулалтыг зээлийн өртөөс хасаж капиталжуулан хөрөнгийн өртөгт бүртгэнэ.

Орлогын татвар

Орлогын татварын зардал нь тайлант үеийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Орлогын татварын зардлыг өмчийн дансанд шууд хүлээн зөвшөөрдөг зүйлстэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Тайлант үеийн татвар гэдэг нь өмнөх жилүүдийн татварын өрийн тохируулга болон тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эсвэл мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээг ашиглан тухайн жилийн татвар ногдох ашиг, татварын алдагдалд суурилан хүлээгдэж буй татварын өр эсвэл авлага юм.

Татвар ногдох орлого бий болох нь тодорхой болсон бүх татвар ногдох түр зөрүүнд хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрдөг. Тайлант үеийн эцсээр хүчин төгөлдөр болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээ (татварын хууль)-нд үндэслэсэн хөрөнгө нь хэрэгжих буюу өр төлбөрийг телөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварыг хэмждэг.

3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	2022 мян.төг	2023 мян.төг
Банкинд буй мөнгө		
Голомт банкан дахь харилцах /3305139985/	1,000.0	85,084.0
Капитрон банкан дахь харилцах /3011042082/	-	20.0
Капитрон банкан дахь хадгаламж /3011042042/	-	500,023.2
	1,000.0	585,127.2

4. ДАНСНЫ АВЛАГА

	2022 мян.төг	2023 мян.төг
Зээлийн багц-“Бичил глобус финанс ББСБ” ХХК	-	18,578,978.5
Хүүгийн авлага	-	417,468.5
	-	18,996,447.0

ТЗК нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч “Бичил глобус финанс ББСБ” ХХК-тай 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан 23/607 дугаар бүхий “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-ний дагуу Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан шаардлагыг хангасан 20,000.0 сая төгрөгийн үлдэгдэл бүхий 1130 зээлийн гэрээг багцлан шилжүүлж авчээ.

Тайлант онд 6,435.7 сая төгрөгийн үлдэгдэл бүхий 1482 зээлийн гэрээг багцлан нэмж авсан ба 129.7 сая төгрөгийн үлдэгдэл бүхий 8 зээлийн гэрээг буцаан шилжүүлж, үндсэн зээлэнд 7,727.1 сая төгрөг, үндсэн зээлийн хүүгийн төлбөрт 3,112.0 сая төгрөг, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрт 10,023.6 сая төгрөг төлөгдсөн байна.

Зээлийн багцын гүйлгээний мэдээлэл

Огноо	Нэмж авсан мян.төг	Хасагдсан			Эцсийн үлдэгдэл мян.төг
		Зээлийн төлөлт мян.төг	Багцаас буцаасан мян.төг	Эцсийн үлдэгдэл мян.төг	
Эхний үлдэгдэл					20,000,044.2
2023.06	-	76,935.3		-	19,923,108.9
2023.07	-	1,237,270.0		-	18,685,838.9
2023.08	1,532,189.6	1,204,067.4		-	19,013,961.1
2023.09	857,262.7	1,170,107.7	22,158.6		18,678,957.4
2023.10	1,666,063.6	1,368,355.8	36,157.2		18,940,508.0
2023.11	1,912,859.1	1,325,716.8	12,239.4		19,515,410.9
2023.12	467,373.6	1,344,693.8	59,112.3		18,578,978.5
нийт	6,435,748.6	7,727,146.8	129,667.5		

Тайлант хугацааны эцсийн байдлаар зээлийн багцын 97.3 хувь буюу 18,086.1 сая төгрөгийн 1165 зээл хэвийн, 412.2 сая төгрөгийн 19 зээл хугацаа хэтэрсэн, 80.6 сая төгрөгийн 3 зээл хэвийн бус ангилалтай байна.

5. БУСАД АВЛАГА

	2022 мян.төг	2023 мян.төг
"Бичил глобус финанс ББСБ" ХХК зээл	-	1,855,462.5
	<u>-</u>	<u>1,855,462.5</u>

6. ТАТВАРЫН ӨГЛӨГ

	2022 мян.төг	2023 мян.төг
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	-	129,196.0
Хувь хүний орлогын албан татвар	-	212.1
Хувь хүний орлогын албан татвар /суутгагчийн/	-	79,531.4
	<u>-</u>	<u>208,939.5</u>

Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т заасны дагуу албан татвар ногдуулах орлогын 10 хувиар татвар тооцож өглөг үүсгэн бүртгэсэн.

ТЗК-ийн ТУЗ-ийн 2023 оны 22/09/21 дүгээр тогтоолоор баталсан "Үйл ажиллагааны зардлын төсөв"-ийн дагуу ТУЗ-ийн З гишүүнд нийт 6.0 сая төгрөгийн цалин олгож, цалингаас 424.2 мянган төгрөгийн ХХОАТ суутгасан.

ТЗК-ийн ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 23/25а/08 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ын дагуу үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдаж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх өдрөөс эхлэн хүү тооцохоор тусгасан. Хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн буюу 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрөөс хүү тооцсон.

Үнэт цаасны хүүний төлбөрийг улирал тутамд олгох заалтын дагуу 2023 оны 9 дүгээр сарын 28-нд хүүний төлбөрт 932.6 сая төгрөг, 12 дугаар сарын 28-нд 922.5 сая төгрөг тооцож, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д заасны дагуу 5.0 хувийн татвар суутган 1,768.9 сая төгрөгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд шилжүүлсэн байна.

Суутгагчийн хувь хүнд олгосон орлогын албан татварын тайлангаар 115 хувь хүнд олгосон 765.6 сая төгрөгийн орлогоос 38.3 сая төгрөгийн, 9 байгууллагад олгосон 825.0 сая төгрөгийн орлогоос 41.2 сая төгрөгийн татвар тус тус суутган тайлагнасан.

7. ХҮҮНИЙ ӨГЛӨГ

	2022 мян.төг	2023 мян.төг
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүний өглөг	-	40,548.0
	<u>-</u>	<u>40,548.0</u>

2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс хойши хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүний өглөгийг бүртгэсэн.

8. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ

	2022 мян.төг	2023 мян.төг
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	-	20,000,000.0
	<u>-</u>	<u>20,000,000.0</u>

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

СЗХ-ны 2023 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 181 дүгээр тогтоолоор бүртгэсэн ТЗК-ийн нийтэд санал болгох 24 сарын хугацаатай, жилийн 18.5 хувийн хүүтэй, нэг бүр нь 100.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 200.0 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг урт хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн.

9. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

	2022 мян.төг	2023 мян.төг
Зээлийн хүүгийн орлого		
2023 оны 2-р улирал	-	59,586.2
2023 оны 3-р улирал	-	1,731,764.0
2023 оны 4-р улирал	-	1,748,508.8
	<hr/>	<hr/>
	-	3,539,859.0

ТЗК-ийн орлого нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч “Бэрс финанс ББСБ” ХХК-иас шилжүүлэн авсан зээлийн хүүний орлогоос бүрдэнэ.

10. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

	2022 мян.төг	2023 мян.төг
Үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр	-	271,213.4
Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр	-	37,500.0
Захиргааны үйлчилгээний шимтгэл	-	9,000.0
ТУЗ-ийн цалин	-	6,000.0
Бусад	-	1,338.4
	<hr/>	<hr/>
	-	325,051.8

11. САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

	Хүү тооцсон хоног	2023 мян.төг
2023 оны 2-р улирал	3	30,411.0
2023 оны 3-р улирал	92	932,602.7
2023 оны 4-р улирал	92	932,602.7
	<hr/>	<hr/>
	187	1,895,616.4

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүний төлбөрийг 18.5 хувиар тооцож санхүүгийн зардалд бүртгэсэн.

12. ЭНГИЙН ХУВЬЦАА

	Эзэмшил хувь	2023 мян.төг
Хувьцаа эзэмшигч “Бичил глобус финанс ББСБ” ХХК	100.0	1,000.0
	<hr/>	<hr/>
	100.0	1,000.0

13. ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Тооцсон дүн мян.төг
Нийт хөрөнгө	21,437,759.2
Өөрийн хөрөнгө	1,188,271.7
Урт хугацаат өр төлбөр	20,000,000.0
Богино хугацаат өр төлбөр	249,487.5
Үйл ажиллагааны зардал	325,051.8
Хөрөнгийн зохистой харьцаа	5.78
Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	100

Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасны дагуу "Бичил Эй Би Эс плас ТЗК" ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланда аудит хийллээ.

Аудитыг Ниямазон аудит ХХК-ийн аудитор Т.Оюун, аудиторын туслах М.Батцэцэг, нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ж.Батнасан, захирал З.Цээнээ нар хэрэгжүүлсэн.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АОУС 320-ийн дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайланг, суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг байдлыг 35.4 сая төгрөгөөр төлөвлөлтийн шатанд тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоо шаардлагагүй гэж үзсэн.

Бидний хийсэн аудитын бодлого горим нь санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад зориулагдсан бөгөөд тусгайлан анхаарах шаардлагатай асуудлыг тодорхойлох зорилго агуулаагүй. Компанийн нягтлан бodoх бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг илрүүлэх боломжгүй юм.

Санхүүгийн тайлангийн аудитаар үйлчлүүлэгч байгууллагын дотоод хяналтын системийг үнэлж, менежментийн захидалыг үйлчлүүлэгч түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд, хяналтын сүл тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өгдөг.

Бидний ажигласнаар цаашид санхүүгийн тайланда нөлөөлж болзошгүй асуудлыг толилуулж байна.

1. Тооцооны үлдэгдлийг тулган баталгаажуулах талаар

Илрүүлэлт:

Харилцагч байгууллагуудтай тайлант үе бүрийн эцэст тооцоо нийлж, тооцооны үлдэгдлийг баталгаажуулан, батлагдсан маягтын дагуу баримтжуулах ажил хийгдээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг мөрдөж ажиллах

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын дагуу маягтыг ашиглан харилцагч байгууллагуудтай тооцоо нийлэх зөвлөмж өгч байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.